



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 0786

Чингис хот

2025 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг
зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.6, Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/155 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 4 дүгээр сарын 29-ний өдөр явуулсугай.

2.2025 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулах ажлын хэсгийн дор дурьдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Лхагвабаатар /Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Гишүүд:

М.Хүрэлчулуун /1-р багийн Засаг дарга/
Б.Отгонбаатар /2-р багийн Засаг дарга/
Б.Мөнхбаяр /3-р багийн Засаг дарга/
Ё.Баяртулга /4-р багийн Засаг дарга/
А.Мөнх-Эрдэнэ /5-р багийн Засаг дарга/
Д.Мөнхтуяа /6-р багийн Засаг дарга/
Д.Алтаннараа /7-р багийн Засаг дарга/
Ө.Зоригт /8-р багийн Засаг дарга/

3.Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтанд орсон цэргийн албанд татагдагч иргэн бүрт тараан заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Цэрэг татлагын товчооны гишүүдийг ажиллах нөхцлөөр хангаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

5.Цэргийн штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан хуульд заасан шаардлагын хүрээнд тэнцсэн залуучуудыг хугацаат цэргийн албанд татах, үдэх ажлыг зохион байгуулан 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Аймгийн цэргийн штабт хүлээлгэн өгч, 5 дугаар сарын 05-нд танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

D:\Албан тоот 2015\Zahiraml\Захирамж 2015.doc